



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/190

Мандалговь

"Мандал шилтгээн" ХХК-тай  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Авто замын хашлага, хүйтэн асфальт, битум худалдан авах" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Мандал шилтгээн" ХХК-тай 39,024,000 (гучин есөн сая хорин дөрвөн мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу "Авто замын хашлага, хүйтэн асфальт, битум худалдан авах" ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Мандал шилтгээн" ХХК-ийн захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Л.ДОРЖБАТ



4822150430